

2025.07

VIP 76+

126
ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ
ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ



ТӨР ЦОМХОН,
ИЛҮҮ БҮТЭЭМЖТЭЙ БАЙХАД
**ТӨВЛӨРЧ
АЖИЛЛАНА**

Пүрэвжав

САИНЗОРИГ

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Монгол Улсын Их Хурал




Пүрэвжав САЙНЗОРИГ


- Монгол Улсын Их Хурлын гишүүн
- Хууль зүйн байнгын хорооны гишүүн
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ
ТАНИЛЦАНА УУ

 sainzorig@parliament.mn

 Пүрэвжавын Сайнзориг

 51262569

САНААЧИЛСАН ХУУЛЬ - 4

- Харьяатын тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Монгол Улсад гадаадын ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тоог тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хууль
- Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль

АЖЛЫН ХЭСЭГ АХАЛСАН - 5

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл
- Арилжааны болон дампуурлын харилцааг зохицуулсан хуулийн төсөл
- Шүгэл үлээх журмын талаар хуулийн төсөл
- Бүсчилсэн хөгжлийг эрчимжүүлэх бүтээгдэхүүн солилцооны талаар хуулийн төсөл
- Зөвшөөрлийн тухай хуулийн төсөл

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН - 20

- Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Бусад

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Азербайжаны Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Германы Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейтай харилцах бүлгийн гишүүн
- Монгол-Казахстаны Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Кубын Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Хятадын Парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Японы Парламентын бүлгийн гишүүн



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2025

83

НЭГДСЭН
ХУРАЛДААН

144

БАТАЛСАН
ХУУЛЬ

146

УИХ-ЫН
ТОГТООЛ

2024 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНД ХАМГИЙН ОЛОН УДАА АСУУЛТ АСУУСАН ГИШҮҮН



С.Ганбаатар
34



О.Цогтгэрэл
29



П.Сайнзориг
28



Б.Батбаатар
27



Ж.Баярмаа
24

Эх сурвалж: parliament.mn

2024 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ



П.Сайнзориг

85%

Ирсэн

16%

Чөлөөтэй

0%

Тасалсан

9

Хоцорсон
минут

Эх сурвалж: uih.mn

ХАМГИЙН ОЛОН ХУУЛЬ САНААЧИЛСАН УИХ-ЫН ГИШҮҮН



Эх сурвалж: Lemon press, 2025.06.09



126 ГИШҮҮНТЭЙ АНХНЫ ПАРЛАМЕНТЫН 1 ЖИЛ



П.Сайнзориг

УИХ-ын гишүүн

ТӨР ЦОМХОН, ИЛҮҮ БҮТЭЭМЖТЭЙ БАЙХАД ТӨВЛӨРЧ АЖИЛЛАНА

6 _____
ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ “ХҮНИЙ
ЭРХ” БҮРЭН ХАНГАГДАВ

8 _____
ШИНЭ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН “АНХНЫ” ХУУЛИЙН
ТӨСӨЛ БАТЛАГДЛАА

9 _____
НИЙСЛЭЛИЙГ 14 ХОТОД ХУВААЖ,
ХОТЫН ДАРГАА ИРГЭД ӨӨРСДӨӨ
СОНГОНО

10 _____
ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ
ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ЗАЛУУСЫН
ТОО 65% БУУРНА

11 _____
“ХАРИЙН ДАРАНГУЙЛАЛ ОРЖ ИРНЭ”
ГЭХ АЙДСААР УЛСЫН ХӨГЖЛИЙГ
ГАЦААЖ БАЙНА!

12 _____
ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД БАЙХГҮЙ БОЛ
МОНГОЛЫН АЛЬ Ч САЛБАР
ЦЭВЭРШИХГҮЙ!

13 _____
ГАДААДЫН САЙН ТАМИРЧДЫГ
МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БОЛГОЁ

14 _____
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН
НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦООГ
САЙЖРУУЛНА

15 _____
БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХООРОНДЫН
ШҮҮХИЙН МАРГААНЫГ
ЗАРДАЛ БАГА, ТҮРГЭН ШИЙДВЭРЛЭХ
БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

16 _____
ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ
БҮХ НИЙТИЙН АЖИЛ!

18 _____
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН
БОДЛОГЫГ БОДИТ БОЛГОХ
ШААРДЛАГАТАЙ!

20 _____
БҮТЭЭМЖИЙН, ХЯНАЛТЫН
МЕНЕЖЕР НЭРЭЭР АВЛИГЫН БЯЛУУ
ХҮРТЭЭДЭГ БАЙЖ БОЛОХГҮЙ!

22 _____
ХҮҮХДҮҮД БАГИЙН СПОРТООР
ХИЧЭЭЛЛЭЖ, АМЖИЛТ ГАРГАХ
БОЛОМЖ БҮРДЛЭЭ



28

ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ
ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

29

УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД
“ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ
НЭЭВ

30

ЗЭЭЛДЭГЧИЙН “ХАР ЖАГСААЛТ” ГЭХ
САНХҮҮГИЙН ЯЛ ХАЛАГДЛАА

31

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН “ГУРВАН
ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН ХЭСГҮҮД
АЖИЛЛАЖ БАЙНА

32

ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ
БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БУЮУ
УТААНЫ СОНСГОЛ

33

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН “ХОРИГ”-
ИЙН ХҮРЭЭНД ТӨСВӨӨ ДАХИН
ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛЛАА

34

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ОРОН
ТООГ ХАСАЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ
ЯАМДАД ШИЛЖҮҮЛЭВ

35

21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ
“ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ
ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ
УРАГШИЛЛАА

36

ИМПОРТЫН ГУРИЛЫН ТАТВАРЫГ
ТЭГЛЭСНИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

37

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫГ “ХҮННУ” ХОТ
ГЭЖ НЭРЛЭВ

38

МОНГОЛ УЛСЫН ШИНЭ НИЙСЛЭЛ
ХОТЫГ ИРЭЭДҮЙД СЭРГЭЭН

БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН
БҮРДЛЭЭ

39

ЦУСАА ХАНДИВЛАХ ҮЙЛ ЯВЦ
ЭРСДЭЛГҮЙ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН
БОЛОВСРОНГУЙ БОЛОВ

40

ЭД, ЭРХТНЭЭ ШИЛЖҮҮЛЭХ ЭМЭЭГ
БӨГӨӨД МАРГААНТАЙ АСУУДЛУУДАД
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХИЙГ
ЗОРИЛОО

41

ТӨР ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЖ БҮСЭЭ
ЧАНГАЛНА

42

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН
ӨДРҮҮД АМРАЛТЫН
ӨДӨРТЭЙ ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД
ДАРААГИЙН ӨДӨРТ ШИЛЖҮҮЛНЭ

43

УРАНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР
ХУРИМТЛАЛЫН САН АРВИЖНА



ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ “ХҮНИЙ ЭРХ” БҮРЭН ХАНГАГДАВ

Эрүүгийн хэрэг хянан
шийдвэрлэх тухай хууль
Батлагдсан огноо 2025.06.26



Хүнийг гэрчээр дуудаж мэдүүлэг авчихаад сэжигтэн болгодог, цагдан хорих болсон үндэслэл, нотлох баримттайгаа танилцуулдаггүй, яллагдагчаар татсан тогтоолыг бүрэн эхээр нь үзүүлдэггүй, яллагдагч шүүгдэгч шүүхэд нотлох баримт гаргах бололцоогүй байдаг зэрэг олон асуудлууд өнгөрсөн жилүүдийн туршид хүний эрх зөрчигдөх нөхцөл болсоор ирсэн. Энэ бүхэнтэй өмгөөлөгч хүн үйлчлүүлэгчийнхээ өмнөөс нүүр тулж, мөрдөгч, прокурор, шүүхийнхэнтэй үл ойлголцож яах ч аргагүй мухардалд ордог байсан нь нууц биш!


Хуульд туссан онцлох зохицуулалтууд

1. Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, эсхүл түүнээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх, гэрчийн мэдүүлэг авах үед түүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн бол гэрчийн мэдүүлэг авахыг даруй зогсоох;



2. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч сэжигтнийг баривчлах, таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон үндэслэлд хамаарах нотлох баримттай таслан сэргийлэх арга хэмжээний талаарх шүүхийн хэлэлцүүлгээс өмнө урьдчилан танилцах;

3. Хүн ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхийг хангах хүрээнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан талаарх тогтоолын хувийг бүрэн эхээр нь мөрдөгчийн зүгээс яллагдагчид гардуулан өгөх;



4. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүх, прокурорын шийдвэрийг оролцогчид бүрэн танилцуулж, гардуулан өгөхдөө төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцлаж, гардуулан өгөхөөр хуульд тусгасан;

5. Шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг прокурор, өмгөөлөгч хуулбарлан авах эрхийг баталгаажуулсан;



6. Мөрдөгч, прокурор яллагдагч, шүүгдэгчийг цагаатгах, хэргийг хөнгөрүүлэх нөхцөл байдлыг нотлох чиг үүргээ хэрэгжүүлээгүй бол яллагдагч, шүүгдэгч энэ талаарх нотлох баримтыг шүүхэд гаргах боломжийг нээсэн;

7. Шүүх, прокурор, мөрдөгч яллагдагч, өмгөөлөгчөөс гаргасан хүсэлтийг хэсэгчлэн хангасан, эсхүл хангахаас татгалзсан бол энэ талаарх үндэслэлээ тухайн шийдвэртээ тодорхой тусгах асуудлыг хуульд тусгайлан тусгасан;



Хавтаст хэргийн материалтай танилцах хугацаа



Хамгийн багадаа ажлын **3 хоног**
Үндсэн хугацааг **14 хоног**

Шаардлагатай тохиолдолд **14**
хүртэл хоногоор тухай бүр сунгана

ШИНЭ ПАРЛАМЕНТЫН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН “АНХНЫ” ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДЛАА

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
Батлагдсан огноо 2024.08.30



Хуулийн төсөл нь 126 гишүүнтэй парламентын гишүүдээс өргөн мэдүүлж буй анхны хуулийн төсөл гэдгийг тодотгох нь зүйтэй. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 дэх заалтад “Улсын Их Хурлын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийн төслийг зөвхөн УИХ-ын гишүүн санаачлах ба бусад хуулийн

төслийг өргөн мэдүүлэх, УИХ-аар хэлэлцэн батлахдаа дагалдах хэлбэрээр УИХ-ын үйл ажиллагаа, хуралдааны дэгтэй холбоотой хууль тогтоомжийг өөрчлөхийг хориглоно” гэж заасныг үндэслэн хуулийн төслийг боловсруулав.

Энэхүү хуулийн төсөлд, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 5 дугаар зүйлд Хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмэхээр тусгасан юм.



П.Сайнзориг
УИХ-ын гишүүн

Төсвийн ил тод байдал, парламентын хяналтыг бодитоор бэхжүүлэх чухал алхам хийгдлээ. Төсвийн төслийг нухацтай, үр дүнтэй хэлэлцэхийн тулд УИХ-ын намрын ээлжит чуулганыг 9-р сарын 15-аас эхлэхээр тусгаж, төсвийн төслийг нийтдээ 5 үе шаттай хэлэлцэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсвийн төсөлтэй илүү үр дүнтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

НИЙСЛЭЛИЙГ 14 ХОТОД ХУВААЖ, ХОТЫН ДАРГАА ИРГЭД ӨӨРСДӨӨ СОНГОНО

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
Батлагдсан огноо 2024.06.05

Хот, тосгодын эрх зүйн байдлын тухай хууль нь анхлан 1993 онд батлагдаж байсан. Түүнээс хойш нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал нэлээд өөрчлөгдсөн. Мөн 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн дараа Монгол Улс засаг захиргааны шинэчлэлийг хийхдээ байсан хотуудаа татан буулгаад, засаг захиргааны нэгж буюу хотуудыг сум болгочихсон!
Улаанбаатар хотын хүн ам 1992 оноос хойш гурав дахин өссөн. Тухайн үедээ 575 мянган хүнтэй байсан бол өнөөдөр 1.7 сая хүн бүртгэлтэй байна. Ирж, буцдагтайгаа нийлэхээр 2 сая хүн амтай болж, суурьшлын бүс ч зургаа дахин тэлсэн. Үүнийгээ дагаад маш олон асуудал үүссэн нь нууц биш! Иймд хурсан асуудлыг шийдэхийн тулд дагуул болон бүс нутгийн хөгжлийг дэмжихээс өөр аргагүй.



Тухайлбал, УБ хот 9 дүүрэгтэй буюу дүүргийн 9 Засаг даргатай. Түүнчлэн иргэдийнхээ асуудлыг шийдэх нь байтугай хогоо ч толгой мэдээд ачих төсөв, эрх мэдэлгүй 204 хорооны Засаг даргатай. Үүн дээр нийслэлийн Засаг даргыг оруулан тооцвол 214 засаг даргатай. Гэхдээ эдгээр нь “улс төрийн нам”-ын оролцоотой буюу санал болгож томилогддог. Үүнийг өөрчилж иргэдээс шууд сонгогддог 14 Хотын захирагч, 42 хороололтой болох зорилгын дор уг хууль батлагдсан. Нэг ёсондоо нэгжүүдийг цөөлөхийн зэрэгцээ тодорхой эрх мэдэл олгож буйгаараа энэ хууль чамгүй ач холбогдолтой.

“Хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх хангагдаж байвал хүний эрх хангагдсан орчин гэж үзнэ. Цаашид УБ хот энэ төлөвлөлт рүү явна!

“20 МИНУТЫН ХОТ”
үзэл баримтлалаар 14 хотыг хөгжүүлж, дэд төв байгуулна



ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ЗАЛУУСЫН ТОО 65% БУУРНА

Зөвшөөрлийн тухай хууль
Батлагдсан огноо 2025.05.30

Цахим мөрийтэй тоглоомын хамгийн том хор уршиг нь “донтолт”. Үүнээс үүдэн залуус амьдралаараа бооцоо тавьж, нийгэмд хөл алдаж байна. Амьдралаа алдаж, өр зээлд орсон олон монгол хүн, олон өрх гэрийн зовлон бидний өмнө байгаа нь нууц биш! Иймд улсын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн ажлын хэсгийг ахлан ажиллаж, УИХ-аар хэлэлцэн баталлаа.

“Цахим мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхэлж, бусдад их хэмжээний хохирол учруулбал 2-8 жилийн ХОРИХ ялтай



Эдийн засгийн гэмт хэргийн ХОХИРОГЧДЫН 50% нь 30-39 насныхан

- # 2023 онд эдийн засгийн гэмт хэрэг 200 бүртгэгдэж, 2024 онд 417.2 тэрбум₮ хохирол учирсан!
- # Мөрийтэй тоглоомын 1XBET сайтаар манай улсаас 1.7 ихнаяд буюу 500 сая\$ 110 гаруй агентаар дамжин гадагш гарсан!
- # Сүүлийн 3 жилд давхардсан тоогоор хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаа идэвхтэй явуулж ирсэн!




Хууль батлагдсанаар гарах ЭЭРЭГ ҮР ДҮН

- + Энэ чиглэлийн платформууд хориглогдож, зар сурталчилгаа, агентуудын үйл ажиллагаа бүр мөсөн зогсоно;
- + Цахим мөрийтэй тоглоом тоглох залуусын тоо 65% буурна;
- + Гадагш хяналтгүй гарч буй 500 сая ам.долларт зохих байгууллагаас хяналт тавих боломж бүрдэнэ;
- + Хүүхэд, залуучуудын мөрийт болон бооцоот тоглоом тоглож сэтгэл зүйн хувьд донтох, эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлнэ;
- + Мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэт хэвшсэн ойлголтыг өөрчилж, хүүхэд, залуучуудыг бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд уриалан дуудаж буй хууль бус сурталчилгаануудыг таслан зогсооно;

“ХАРИЙН ДАРАНГУЙЛАЛ ОРЖ ИРНЭ” ГЭХ АЙДСААР УЛСЫН ХӨГЖЛИЙГ ГАЦААЖ БАЙНА!

Монгол Улсад гадаадын ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тоог тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай хуулийн төсөл
Өргөн барьсан огноо 2024.12.19



Сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн зах зээлд эрэлт нийлүүлэлтийн зөрүүтэй байдал нэмэгдэж, ажиллах хүчний хомсдол нүүрлэсэн нь Монгол Улсыг “том сорилт”-ын өмнө авчирч буй. Тухайлбал, Монгол Улсад 1993-2006 оны хооронд төрөлтийн дундаж үзүүлэлт эрс бага байсан нь дотоодын ажиллах хүчний хомсдолыг үүсгэж, энэ хомсдол 2030 он хүртэл үргэлжлэх судалгаа гарсан. Тиймээс уг төлөвийг харгалзаж,

дээрх хуулийн төслийг миний бие нэр бүхий гишүүдийн хамтаар өргөн мэдүүлсэн билээ.

Түүнчлэн УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын “Төрийн бүтээмжийн сэргэлт” дэх Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны

төлбөрийг 50% хөнгөлөх, ингэснээр дотоодоос хангах боломжгүй байгаа ажиллах хүчийг гадаадаас авах боломж бүрдүүлсэн байх үр дүнд хүрэхээр тооцсон байдаг. Энэ хүрээнд бизнес эрхлэгч, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг ажиллах хүчний хомсдолд орсныг цаг алдалгүй таслан зогсоох зорилгоор уг хуулийн төслийг өргөн мэдүүлснийг хэлэх нь зүйтэй!

Хуулийн төсөлд:

Уул уурхай, газрын тос олборлох үйл ажиллагаанаас бусад эдийн засгийн үйл ажиллагааны салбарт 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй бөгөөд энэ хугацаанд ажил олгогчийг гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг тусгав.



ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИД БАЙХГҮЙ БОЛ МОНГОЛЫН АЛЬ Ч САЛБАР ЦЭВЭРШИХГҮЙ!

Шүгэл үлээх журмын талаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч

Авлигатай тэмцэх хамгийн бодитой алхам бол “мэдээллийг ил, тод” болгох. Үүнтэй уялдаад мэдээлэл өгч байгаа этгээдийг хамгаалах асуудал яригдана. Тэгэхээр шүгэл үлээх ажиллагааг авлигатай тэмцэхээс гадна хүүхдийн эрхийн зөрчил, гэмт хэрэг, экологийн эсрэг хууль бус үйл ажиллагаа, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр дэмжих нь зүйтэй юм. Харин шүгэл үлээснийхээ төлөө иргэн аливаа нэг төрийн байгууллагын, албан тушаалтны дарамтад орж, “матаач, ховч” гэх зэргээр нэр хүндээ гутаалгаж доромжлуулдаг байж болохгүй!

“ Нийтийн сайн сайхны төлөө ажил, амьдралаа эрсдэлд оруулж шүгэл үлээсэн иргэдийг хамгаалахаас гадна урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ!



Шүгэл үлээгч нар байхгүй бол Монголын аль ч салбар цэвэршихгүй! Энэ үүднээсээ ажил, амьдралаа эрсдэлд оруулж шүгэл үлээсэн иргэдийг хамгаалахаас гадна урамшууллын тогтолцоог бий болгоход анхаарч байна. Тодруулбал, өмнө нь шүгэл үлээх үйл ажиллагааг татварын хууль тогтоомж дээр хэрэглэж байсан. Нэг ёсондоо, татвараас зугтсан, зайлсхийж байгаа

компаниудын талаар болон экологийн эсрэг зөрчлийн талаар мэдээлэл өгвөл шагнаж, урамшуулдаг байсан гэсэн үг. Тэгвэл энэ удаа авлигатай тэмцэх үйл ажиллагаа, албан тушаалтнуудтай холбоотой асуудлаар шүгэл үлээсэн этгээдийг хамгаалах эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгоход тус ажлын хэсэг фокуслан ажиллаж байна.


Татварын зөрчил илрүүлсэн иргэдийг АНУ-д **10-30%**, БНСУ-д **2 тэрбум**



вон хүртэлх мөнгөн дүнгээр шагнаж, урамшуулдаг

ГАДААДЫН САЙН ТАМИРЧДЫГ МОНГОЛ УЛСЫН ИРГЭН БОЛГОЁ

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
Батлагдсан огноо 2025.07.09



Дэлхийн улс орнууд спортоор дамжуулан үндэсний үнэт зүйл, амин чанар, бахархлаа улам бэхжүүлж, хүүхэд, залуучуудыг спортын нөлөөгөөр хүсэл мөрөөдөлдөө тууштай, тэвчээр хатуужилтай, зөв төлөвшилтэй болгоход нь ихээхэн анхаарч байна. Түүнчлэн олимпын үзэл санааг түгээн дэлгэрүүлж, спортод өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс амжилт гаргах магадлалтай Гадаадын иргэнийг өөрийн улсын нэр дээрээс оролцуулах зохицуулалт дэлхийн улс орнуудад ч хүчтэй өрнөж буйг хэлэх нь зүйтэй!

Монгол Улс олимпын түүхийн хугацаанд жүдо, чөлөөт бөх, бокс, буудлагын спортоор медаль авсан байдаг. Цаашид олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын бусад төрөл ялангуяа багийн спортыг эрчимтэй хөгжүүлэх, хүний нөөцөө бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэхэд тамирчид, спортын холбоод, клубүүд, зүтгэлтнүүдийн оролцоо, салбарын эрх зүйн орчин нэн чухал байгаа юм. Иймд миний бие нэр бүхий гишүүдийн хамтаар дээрх хуулийн төслийг боловсруулан өргөн барьж, чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдлаа.

Хуулийн төсөлд:



- “Олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд онцгой амжилт гаргасан буюу гаргах боломжтой гадаадын иргэнийг Ерөнхийлөгч тус хуульд заасан нөхцөлийг үл харгалзан Монгол Улсын харьяат болгож болох агуулга;



- Олимпын төрлийн спорт болон багийн спортыг хөгжүүлэх зорилгоор гадаадын дасгалжуулагч, мэргэжилтэнг урьж ажиллуулбал ажил олгогчийн төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг тусгав.

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛНА

Хүнсний тухай хууль
Өргөн барьсан огноо 2025.06.19



Хүнсний баталгаат байдал, ханган нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулж, хэрэглэгчдийн хүртээмжтэй, шим тэжээллэг, чанартай, баталгаат хүнсээр хангах зорилгоор 13 жилийн дараа ХҮНСНИЙ ТУХАЙ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ.

Хуулийн төсөл батлагдсанаар:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо иж бүрэн цогц байдлаар хэрэгжиж, хүнсний баталгаат байдал сайжрах төдийгүй хүнсний экспортын чанар сайжирч, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ;
2. Хүнсний хяналтын тогтолцоог оновчтой болгосноор хүнсний сүлжээнд бүхэлд нь буюу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл, хүнсний үйлдвэр, тээвэр логистик, гадаад, дотоодын хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, түгээлт, хэрэглэгчийн хүнсний хэрэглээнд тавих хяналт сайжирна;
3. Хүн амыг шим тэжээллэг, чанартай, баталгаатай хүнсээр хангах боломж нэмэгдэж, халдварын бус өвчлөл буурч, түүнтэй холбогдох зардал багасна;
4. Хэрэглэгч бодит мэдээлэлд тулгуурлан сонголтоо хийх чадвар, дадал төлөвшихөөс гадна хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хариуцлага дээшилж, хүнсний баталгаа сайжирна;
5. Төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ;

БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХООРОНДЫН ШҮҮХИЙН МАРГААНЫГ ЗАРДАЛ БАГА, ТҮРГЭН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

Өнөөдөр манай улсад бизнес эрхлэх нөхцөл байдал түвэгтэй, бизнесийн маргааныг шийдвэрлэх цаг хугацаа удаашралтай байгаа. Үүний цаана бизнесийн эргэлт, мөнгөн хөрөнгө гацдаг, бизнес эрхлэгчдийн итгэлцэл эвдэрдэг. Иймд бизнес эрхлэгч хоорондын шүүхийн маргааныг зардал багатай, хялбар, түргэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх, өмгөөлөгч шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулдаг нөхцөлөөс зайлсхийх, шүүхийн шийдвэр нь биелдэг, гэрээний үүрэг хангагддаг байх нь нэн чухал байна.

Арилжааны болон дампуурлын харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хэсгийн ахлагч

Тухайлбал, нэн түрүүнд бизнесийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал бий. Гэрээг бичгээр үйлдэнэ гэж хуульд тусгасан ч бизнесийн түншүүд гэрээгээ цахимаар үйлдэж, мөнгөө шилжүүлэн бараа материалаа солилцчихдог. Улмаар маргаан үүсээд шүүхэд очдог асуудал нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих бус, саатуулах үйлдэл болж буй!

“Арбитр, эвлэрүүлэн зуучлах чиглэлийн хууль, эрх зүйн механизмуудыг тодруулж үзэх ёстой!”

УИХ-ын гишүүн **П.Сайнзориг**:
“Х” ТАЙЛАН ГАРГАДАГ ЗОМБИ КОМПАНИУД
БИЙ БОЛЖ, ТАТАН БУУЛГАЖ БОЛДОГГҮЙ!

Төлбөрийн чадваргүй болсон компанид иргэний хэрэг үүсгээд, төлбөр оногдуулах шүүхийн шийдвэр гардаг. Тэгэхээр тухайн төлбөрийн чадваргүй болсон компанид дампуурлын хэрэг үүсгэж, тэр эрсдэлийг хуваарилах эсвэл тэр компанийг аврах төлөвлөгөө гаргах, бүтцийн өөрчлөлт хийх замаар бизнесийг сэргээх асуудлыг шүүхийн оролцоотойгоор сонирхогч талуудын хүсэлтээр хийх арга бий. Гэтэл үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчин маш тодорхойгүй байдаг. Тиймээс “х” тайлан гаргадаг зомби компаниуд бий болж, татан буулгаж болдоггүй, татварын болон нийгмийн даатгалын өр ширтэй явсаар байдаг. Иймд бие даасан арилжааны хуулийг иргэний хуультайгаа уялдуулж боловсруулах, үүнтэй хамт Дампуурлын тухай хуулийг шинэчилж Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль болгох, Арилжааны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай, Эвлэрүүлэн зуучлах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг цогц байдлаар нь шинэчлэхэд анхаарч байна.



ХҮНИЙ ЭРХ ЗӨРЧИГДӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ БҮХ НИЙТИЙН АЖИЛ!

Хүний эрх, эрх чөлөөг хангах тухай хяналтын сонсгол
2024.11.20



УИХ-ын нэр бүхий гишүүдээс сонсгол хийх хүсэлтийг УИХ-ын даргад гаргасны дагуу Хууль зүйн байнгын хороо хуралдаж 2024.11.20-ний өдөр сонсгол хийхээр шийдвэрлэсэн. Улмаар “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголыг миний бие ахлан зохион байгуулсан билээ.

“ Хэн нэгэнд гэмт хэрэг тулгаж, үүрүүлж, эрхийг нь зөрчиж болохгүй! Магадгүй түүний ард жинхэнэ гэмт хэрэгтэн ялгүй өнгөрөх боломжтой.



Хүний эрхийн хэрэгжилтийн асуудалд ХЭҮК-ын дүгнэлтүүд нэн чухал байдаг. Сонсголоор эрүү шүүлт тулгахаас ангид байх ажлын хэрэгжилт Монгол Улсад ямар байна, мөн ойрын хугацаанд гарсан зарим

зөрчлүүдийг хэрхэн арилгах вэ гэдгийг ХЭҮК-ын дүгнэлт, шүүх байгууллагын мэдээлэл, Засгийн газар /Боловсролын яам, ЭМЯ, БХЯ/-ын яамдын байр суурь зэрэг тал талын мэдээлэлд тулгуурлаж

сонсов. Ингэснээрээ цаашид хууль, эрхзүйн орчныг хэрхэн боловсронгуй болгох, төсөв мөнгө нь ямар байх уу гэдэг асуудал илүү тодорхой болох юм.

СҮҮЛИЙН 10 ЖИЛИЙН ХУГАЦААНД

Цэргийн анги, байгууллагад **468**
гэмт хэрэг, сахилгын зөрчил бүртгэгдсэнээс



242

нь зэвсэгт хүчинд,

217

нь хилийн цэрэгт,

9

нь дотоодын цэрэгт
хамааралтай байна!


ХЭҮК ДАРААХ АСУУДАЛД ШҮҮМЖЛЭЛТЭЙ ХАНДАЖ БАЙНА!

- Төрийн нууц, гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажилтай холбоотойгоор үйлдэгдэж, хяналт тавих, нотлоход хүндрэлтэй болж байна. Хорих ял эдлэх, баривчлах шийтгэл эдлэх хүмүүсийн тоо нэмэгдэж буйтайтай холбоотойгоор хорих анги, баривчлах төв болон хүний эрхийг хязгаарлах газруудад эрүүдэн шүүх, хүнлэг бус харьцах эрсдэл бодитойгоор нэмэгдсэн!
- Хорих ангиудын орчин нөхцөл НҮБ-ын хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм, насанд хүрээгүй!
- Цэргийн алба хаагчдын дунд дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчил, хүний амь эрсдэх нөхцөл байдал гарсаар байгаа нь хүний эрхийн мэдлэг ойлголт хангалтгүй, хариуцлагын тогтолцоо сул байгаатай холбоотой!
- Гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүнээс гэм буруугаа өөрөө нотлохыг шаардах, мэдүүлэг авахыг албадах хандлага гарсаар байна!
- ХЭҮК-оос хийсэн хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх үзлэг, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллээс үзэхэд тайлбар, мэдүүлэг авахад зориулсан тусгайлан бэлтгэсэн өрөө хүрэлцээгүй, камерын хяналт хангалтгүй, камерын дүрс бичлэгийг хадгалах, хамгаалах, хуулбарлан авах боломж хомс зэрэг нөхцөл түгээмэл байна.
- Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан нэгжийг байгуулах асуудал шийдвэрлэгдэхгүй байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГЫГ БОДИТ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ!

Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан АСУУЛГА

2024.07.24



Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэл бөгөөд нийтдээ 1,7 сая орчим хүн оршин суудаг. 1990 оноос өмнө баригдсан 1077 блок угсармал орон сууцанд нийтдээ 45 мянган өрх буюу 200 мянган иргэд амьдардаг. Насжилт өндөр, засвар хийх шаардлагатай орон сууцны барилгууд нь халаалтын эрчим хүчний маш өндөр хэрэглээтэй, дулаан алдагдал ихтэй байгаа нь нууц биш! Иймд гадна дулаалга, дээвэр засвар, цахилгаан шатны шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүссэн!


Иймд миний бие уг асуудлыг хөндөж, шийдвэрлүүлэх талаар Ерөнхий сайдад хандан 2024 оны 07 сарын 24-ний өдөр **АЛБАН БИЧИГ** илгээсэн юм. Тодруулбал, дээрх асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах **78,3** тэрбум төгрөгийг Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд тодотгол хийх тохиолдолд тусгах эсхүл 2025 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авч өгөхийг хүссэн билээ.



УБ хотод ашиглалтын шаардлага хангахгүй, яаралтай засвар хийх шаардлагатай **379** орон сууц байна. Эдгээрээс хамгийн өндөр насжилттай нь 1950 онд ашиглалтад орсон **75** жилийн настай орон сууц байна!



- Дээврийн засвар хийх **120**
- Гадна ханын засвар, дулаалга хийх **169**
- Лифт солих **90** барилга байна



115 барилга нь 1950-1979 онд ашиглалтад орсон

барилга нь 1980-1999 онд ашиглалтад орсон **127**

137 барилга нь 2000-2016 онд ашиглалтад орсон

Дээврийг засварлаж, гадна ханыг дулаалснаар:




- Барилга тус бүрт 26.8%-ийн дулааны эрчим хүчний хэмнэлт гарч
- Ус, дулаан дамжуулах төвийн дулааны ачаалал 61.5 Гкал цаг буюу 16% буурч
- Иргэдийн эрүүл, аюулгүй, тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ

БҮТЭЭМЖИЙН, ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР НЭРЭЭР АВЛИГЫН БЯЛУУ ХҮРТЭЭДЭГ БАЙЖ БОЛОХГҮЙ!

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж тавьсан АСУУЛГА

2025.03.28



Хуулиар чиг үүргийг нь тодорхойлоогүй, Засгийн газрын гишүүн, яам, агентлагийн чиг үүрэгтэй давхардсан зөвлөл, төв, хороо, комисс зэрэг нэршилтэй байгууллагуудыг байгуулах замаар төрийн алба данхайх, төсвийн үр ашиггүй зардал нэмэгдэж байна. Тодруулбал, Төрийн өмчит компани, банк, улсын үйлдвэрийн газарт “бүтээмжийн менежер”, “хяналтын менежер” гэх нэршил бүхий дэд, орлогч дарга /захирал/-ын статустай албан тушаалыг бий болгож, томилон ажиллуулж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэж байгаа эсэх талаар иргэд, олон нийт шүүмжлэлтэй хандаж байна! Иймд уг асуудлаар миний бие УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, З.Мэндсайхан нарын хамтаар хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд АСУУЛТ тавилаа.

Энэ хүрээнд Ерөнхий сайдаас “бүтээмжийн менежер”, “хяналтын менежер” гэх Төрийн хэмнэлтийн хуулиар хориглосон орлогч захирлын цалин хангамж, статустай албан тушаалыг бий болгож нийтдээ 42-ыг томилсон бөгөөд, энэ тоог нэмж 100-д хүргэх талаар хариу ирүүлсэн!

Засгийн газар яамд, агентлагаас гадна нийт 57 хороо, комисс, зөвлөл байгуулагдсанаас хуульд тухайлан чиг үүргийг нь заагаагүй 10 хороо, 4 зөвлөл байгуулагджээ. Энэ 14 зөвлөл, хороо нь 90 орон тоотой байх ба 30 тэрбум төгрөгийн төсөв зарцуулж байсан!



П.Сайнзориг
УИХ-ын гишүүн

Үүнээс харахад хуулиар байгуулагдсан яамд, агентлагуудтай чиг үүрэг давхардсан, төрийн албаны шалгалт өгөөгүй, улс төрийн авлига болгож төрийг данхайлгаж, эзэн биегүй хоорондоо хариуцлагаа чихсэн эрх мэдлийн бүтцүүдийг үлэмж нэмэгдүүлж буй нь Үндсэн хуулийн бус бөгөөд төрийг удирдах, засаглах боломжийг алдагдуулахад хүргэж байна. Дахиж ийм нэршлээр албан тушаалтнууд гаргаж ирмээргүй байна!

Монголбанкнаас арилжааны банканд тавих хяналтын талаар Монголбанкны
Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд **АСУУЛГА** тавьлаа

2025.06.27



Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу Төв банк / Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад “банк болон хуульд тусгайлан заасан этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих;” гэж, мөн хэсгийн 7 дахь заалтад “банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах” гэж Монгол банкны хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор дараах асуултыг хүргүүлээ.

Санхүүгийн зохицуулах хороо хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар
Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамцад **АСУУЛГА** тавьлаа

2025.06.27



УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасны дагуу танай байгууллагын хяналт, зохицуулалтын чиг үүрэгт хамаарах зээлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгож буй зээлийн бодит өртгийн бүтэц, өртгийг хэрхэн, ямар аргачлал, журам, хууль тогтоомжийн дагуу тогтоож байгаа мэдээллийг зээлийн бүтээгдэхүүний төрөл тус бүрээр, түүнчлэн зээлийн хүүгээс бусад зээлийн өртөг болох шимтгэл, хураамжийг тогтоодог болон тогтоодоггүй зээлийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэл, шимтгэл, хураамжийг үндэслэлтэй тогтоодог эсэх, шимтгэл, хураамж холбоотой зээлдэгч, хэрэглэгчийн ирүүлдэг гомдлын агуулга, тоо /сүүлийн таван жилээр/, энэ чиглэлээрх хэрэглэгчийг хамгаалах бодлогын талаарх мэдээллийг бичгээр илрүүлэг хүслээ.

ХҮҮХДҮҮД БАГИЙН СПОРТООР ХИЧЭЭЛЛЭЖ, АМЖИЛТ ГАРГАХ БОЛОМЖ БҮРДЛЭЭ

Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарт хандсан **САНАЛ**

2024.10.07



Сонгинохайрхан дүүрэг болон Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтыг түшиглэн багийн спортыг хөгжүүлэх, хүүхэд залуучуудыг хөгжих эрхийг хангах үүднээс БЭЙСБОЛЛ, СОФТБОЛЛ тайлбай байгуулах талаар хотын дарга Х.Нямбаатарт хандан САНАЛ хүргүүллээ.

Тухайлбал, Монгол Улс 2027 онд Ази тивийн Тийболлын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар эрхээ авсан бөгөөд зориулалтын талбайг барьж байгуулах асуудал чухал байна! Түүнчлэн манай хүүхэд, залуучууд өвлийн улиралд бэлтгэл хийх боломжгүй байдаг бөгөөд битүү зориулалтын талбай дутагдалтай байгаа юм.

Иймд Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг болон Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд хүүхдийн сурах, хөгжих эрхийг хангах, багийн спортыг хөгжүүлэх үүднээс Бэйсболлын талбай барих газрын асуудлыг нийслэлийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах, уг талбайг барьж байгуулах хөрөнгө оруулалтыг нийслэлийн төсөвт тусгаж өгөхийг хотын даргаас хүссэн бөгөөд СХД-ийн 5 дугаар хороонд бейсболлын талбай баригдахаар болж, шаардагдах хөрөнгө нь Нийслэлийн төсөвт суусныг дуулгахдаа таатай байна.



ТӨР ЦОМХОН, ИЛҮҮ БҮТЭЭМЖТЭЙ БАЙХАД ТӨВЛӨРЧ АЖИЛЛАНА



Хуулиа мэддэг, хэл амнаас айдаггүй, хэлэх гэснээ хэлчихдэг, хийх гэснээ хийчихдэг хувийн биш нийтийн эрх ашгийг нэгдүгээрт тавьдаг харьцангуй шударга хуульчид 126 гишүүнтэй **ШИНЭ ПАРЛАМЕНТАД** цөөнгүй бий.

Байгаль орчны яамны мэргэжилтнээс Хууль зүйн бодлогын газрын дарга, Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн дарга, Улаанбаатар хотын нэгдүгээр орлогч, өдгөө УИХ-ын гишүүн хүртэл дэвшин ажиллаж байгаа хүн бол төрийн мэргэшсэн албан хаагч, хуульч Пүрэвжавын Сайнзориг.

Хуульчийн мэргэжил шударга, тодорхой байхыг шаарддаг...

П.Сайнзориг 2005 онд Отгонтэнгэр Их сургуульд хуульч мэргэжил эзэмшээд, 2006 оны 1 дүгээр сараас БОАЖЯ-нд Төрийн захиргааны удирдлагын газарт гурав орчим жил ажиллаад, 2008 онд мэргэжил дээшлүүлэхээр Австрали улсыг зорьсон. Дөрвөн жилийн дараа эргэж ирээд мөн яамандаа ажилласан юм. Үүний дараа ХЗДХЯ-нд шалгалт өгч, сонгон шалгаруулалтад нэгээр тэнцэж орсноор хуулийн төсөл боловсруулах нарийн чимхлүүр ажилтай зууралдаж, хуульчийн хувьд “элдүүр ханах”-ын эхлэл болсон аж. Чухам тэр цагаас эрх зүйн шинэтгэлийн ажилд манлайлан оролцож, нийгмийн сайн сайхны төлөө сэтгэл чилээн, бодлоо уралдуулж эхэлжээ.

Бүр тодруулбал, 2015 онд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны зөвлөхийн албан тушаалд томилогдон эрүүгийн эрх зүйн реформууд, эндээсээ үргэлжлүүлэн ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрыг 10-аад жил ахалсан хугацаандаа Нийтийн эрх зүйн болон Захиргааны эрх зүйн хуулиуд дээр ажиллав. Ингэхдээ тус хуулиудыг хүний эрхийн мэдрэмжтэй, бизнесийг дэмжих, хаалттай зүйлсийг нээлттэй болгох талаас нь илүү их бодож, анхаарч боловсруулсан юм. Нэг үгээр хэлбэл, эрх мэдлийн гэдэг юм уу жендэрийн эрх тэгш байдлыг хангах талд нь илүү олон зохицуулалт оруулахыг хичээсэн гэсэн үг. Үүний дараагаар Үндсэн хуулийн хоёр удаагийн өөрчлөлт буюу өнөөдрийн улс төрийн сонгуулийн тогтолцоотой холбоотой хэсгүүдийг гардан боловсруулжээ.

2022 онд системийн авлигатай тэмцэх тухайн үеийн Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн анхны алхам нь нүүрсний экспортыг ил тод, нээлттэй болгох, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, энэ хүрээнд ковидын дараах эдийн засгийн сэргэлтийг авчрах байсан. Нэг ёсондоо, нүүрсний хулгай луйврууд дэлгэгдэж, тэр хэрээр эдийн засгийн томоохон бүлэглэлүүдтэй нүүр тулсан үе. Чухам тэр үед П.Сайнзоригт итгэл хүлээлгэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсон нь санамсаргүй томилгоо яав ч биш! Түүнчлэн тэрбээр орон нутгийн “Тавантолгой” ХК-д бүрэн эрхэт төлөөлөгчөөр зургаан сарын хугацаанд ажиллахдаа Засгийн газрын нүүрсийг биржээр арилжаалах, тээвэрлэлтийг тендерээр явуулах зэрэг бэлтгэл ажлуудыг хийж, жижиг Тавантолгой, ЭТТ компанийн хооронд үүссэн өр авлагыг шийдсэн юм.

***Хүнд зориулсан
хотыг бий болгохын
төлөө ажиллав...***





Манай хот хэзээ хамгийн сүүлд ийм эрчтэй, “эзэнтэй юм шиг байлаа даа” гэж бодтол ажилласан улсууд бол Х.Нямбаатар болон түүний бүрдүүлсэн хамт олон. Дур дураараа барьсан гараашнаас авхуулаад байшин сав байсан ч хүний төлөө биш л бол буулгаж буй. Хэчнээн өндөр байшин, барилга ч гэлээ хүний, олонхын эрх ашигт харшлахаар л бол төрийн төмөр нүүр харуулан нурааж л байна. Цаашилбал, нийслэл орон нутгийн өмчийг арга залиар авчихсан, түүндээ хувийн өмч мэт авирлаж суудаг дарга, эрх мэдэлд ойр, бизнесмен нэртэй этгээдүүдтэй хуулийн хүрээнд тэмцэж, гол нь хүнд зориулсан хотыг бий болгохын төлөө ажилласан юм.

Нэхэн сануулбал, хот хэмээх их айлын гал тогоонд ажиллаж буй хуульчийнхаа хувьд эрх зүйн орчныг сайжруулахад бүрэн фокусласан гэж болно. Тухайлбал, 2023 онд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хуулийг баталж, 30 гаруй хуулиудыг дагаж боловсруулсан. Мөн хотын эдийн засаг, бие даан хөгжих бололцоог бүрдүүлж гадаад, дотоод үнэт цаас гаргах хуулийн орчныг бүрдүүлэхийн сацуу Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай зэрэг хуулиудын ажлын хэсэгт орж, заримыг нь ахалж ажиллалаа. Эдгээр нь хотын эмхэрч, цэгцрэх эхлэл байсан ч байж болох юм. Учир нь эзний сэтгэлээр хандсан бүхэн хөгжиж дэвждэг зүй тогтолтой билээ.

Ийн 2006 оноос хойш түүний баг хамт олонтойгоо боловсруулсан “усгүй болтол нь шахсан” 100 гаруй бие даасан үзэл баримтлалтай хуулийн төслүүд нь өнөөдрийн хууль зүйн салбарын шинэчлэгчдийн нэгэн болгон төлөвшүүлсэн гэхэд хол зөрөхгүй болов уу...

***Төрийг цомхон, илүү
бүтээмжтэй байх чиглэлд
анхаарч ажиллана...***

Хууль гэдэг өөрөө логикийн шинжлэх ухаан. Энгийнээр хэлбэл хүн судлал. Хүнээ судалж байж нийгмийн харилцаа, хүний зан үйлийг зөвөөр зохицуулж, олон эрх ашгийг тэнцвэржүүлж, муу зан үйлийг хязгаарлаж, сайныг хамгаалах эрх зүйт орчныг бүрдүүлж, хэрэгжүүлж чадна гэсэн үг. П.Сайнзориг энэ зарчмаар асуудалд ханддаг нь заримдаа “хэнхэг” эсхүл “хэрүүлч” ч юм шиг харагддаг талтай. Үнэндээ л үсчин харайж, албан тушаалын лифтэнд сууж бус төрийн албанд мерит зарчмаар ажиллаж, өнөөдрийн парламентад Сонгинохайрханчуудын итгэлийг хүлээн орж ирснийг нь дээр дурдсан ажлууд бэлхнээ нотолж байна.

Монгол Улсын түүхэнд анх удаа мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн 126 гишүүнтэй, таван намын төлөөлөл бүхий шинэ парламент бүрдсэнээр төлөөллийн зарчим илүү батажсан гэж болно. Тэдэнд УИХ-ын үйл ажиллагааг мэдрэхээс аваад нийгмийн шударга ёсны хүсэмжлэл дээд цэгтээ хүрсэн эгзэгтэй цаг үед хүний эрх, хуульт ёс, шударга байдлын зарчмыг хангасан хууль тогтоомжийг батлан гаргах хариуцлагатай үүрэг бий!

Энэ хүрээндээ ч П.Сайнзориг гишүүн чуулганы танхимд шалдар, булдар, хаа хамаагүй зүйл ярихгүй, шаг хийсэн асуулт асууж, тодорхой саналаа хэлчихдэг нь түүнийг хоосон цэцэрхэх бус бодитой ажиллахыг эрмэлздэгийг харуулдаг. Тоймловол, УИХ-ын гишүүн П.Сайнзориг бүрэн эрхийн эхний нэг жилийн хугацаанд ажлын хэсгийг ахалж батлуулсан 3, бизнесийн хөгжлийг дэмжих чиглэлд арилжааны болон төлбөрийн чадваргүйтлийн тухай хуулийн төслийг боловсруулж дуусгаад ХЗДХЯ-нд хүлээлгэж өгөөд байна. Мөн спортыг дэмжих чиглэл Харьяатын болон Татварын тухай хуулийн төсөл. Одоогоор өөрийн нэр дэр өргөн барихаар хоёр хуулийн төслийг боловсруулж байна. Түүнчлэн УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан 20 гаран хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч болон гишүүнээр ажиллаж, энэ парламентын хугацаанд хамгийн олон хууль санаачилсан гишүүдийн тоонд ч ороод явж байгаа.

Төр илүү бүтээмжтэй байх чиглэлд түлхүү анхаарч, УИХ-ын бусад гишүүддээ боловсруулж байгаа хуулийн төслүүдээ ойлгуулах тал дээр хамтарч ажиллахад анхаарч буй.

Б.Хонгорсайхан





МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

126 ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ

2024 оны намар,
2025 оны хаврын
чуулганаар батлагдсан
гол хуулиуд болон
парламентын
онцлох ажил



ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

76 гишүүнтэй өмнөх парламент 2023 оны тавдугаар сарын 21-ний өдөр Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах түүхэн шийдвэр гаргаснаар өнөөдрийн 126 гишүүнтэй анхны парламент “мэндэлж” 2024-2028 оны стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлын бодлого, үйл ажиллагааны цөмд хүн байна. Шинээр гарах хууль бүр хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, олон талт түншлэлийг сайжруулсан, үндэсний язгуур эрх ашгийг цогцлоосон шинжийг агуулах юм. Мөн иргэн хууль санаачлах, хууль боловсруулахад оролцох, саналаа тусгах, биелэлтэд хяналт тавих, зэргээр улс орны бодлогод ард иргэдийн дуу хоолойг тусгадаг болсноор иргэдийн оролцоотой Ардчилсан парламентын мөн чанарыг бататгасан томоохон өөрчлөлт болов.

УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ

5 намын оролцоотой ажлын хэсэг нийт

5 зорилго, түүнд хүрэх

17 зорилтыг дэвшүүлсэн юм.



Х.БУЛГАНТУЯА

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Энэхүү стратеги төлөвлөгөө нь Улсын Их Хурлын гишүүд, УИХ-ын Тамгын газрын төлөвлөгөө биш. Үүний гол зорилго нь Улсын Их Хурлаас хэлэлцэн батлагддаг хууль тогтоомжууд иргэд, олон нийтэд ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний эрхийн зөрчилгүй нийгмийг цогцлооход чиглэж байгаа.



П.САЙНЗОРИГ

УИХ-ын гишүүн

Бид юуны төлөө яваа, ямар үнэт зүйлийг бэхжүүлэх гэж байгаа талаас нь ойлгож, дэмжиж байна. УИХ-ын дэгийн үйл явцыг илүү тодорхой, нээлттэй болгож, Байнгын хороодын эрхлэх асуудлын хуваарилалтыг оновчтой болгосноор цаашдаа парламентын стратеги зөв болно.





Н.УЧРАЛ

УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга

Ураны төсөл дээр Монголын урдаа барьдаг эрдэмтэн судлаач, орчин цагийн шилдэг хуульч, эдийн засагчидтай хамтран ажиллаж “авлига, ашиг сонирхол бүхнийг сөрж” ард нь гарсандаа сэтгэл дүүрэн байна. Нэг ёсондоо, Монголчууд Монголдоо, Монгол хүндээ үр өгөөжтэй, харилцан ашигтай, хамтран ажиллаж чаддаг, хэлэлцэн тохирч болдгийг батлан харууллаа.

Уранаа ашиглах дуусдаггүй яриаг дуусгалаа



П.САЙНЗОРИГ

УИХ-ын гишүүн

Манай улс дан ганц нүүрсний экспортоос хараат байж болохгүй. Нүүрсний үнэ унахад эдийн засагт асар том цохилт өгнө. Тиймээс бусад төрлийн буюу Уран болон газрын ховор элементүүдийг олборлох ёстой.

Уран болон газрын ховор элементүүдийг олборлох ёстой!

УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД “ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ НЭЭВ

2023 онд Монгол, Франц улсын Төрийн тэргүүнүүдийн харилцан айлчлалын үр дүнд, 21-р зууны эрчим хүчний гол эх үүсвэрээр нэрлэгдэж буй ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд ураныг олборлох хэлцэл үзэглэгдэх хаалга нээгдсэн юм. Үүнээс хойш Л.Оюун-Эрдэнийн тэргүүлж буй Засгийн газар Монгол Улсын шинэ 30 жилийн хөгжлийг тодорхойлж, сэргэлт авчрах 14 мега төсөлд ураны төслийг оруулж, шаардлагатай хууль тогтоомжийг шинэчилж, УИХ-аар хэлэлцэн батлуулсан. Үе үеийн эрх баригчдын дунд яригдсан ч маргаан дагуулсаар эцэст нь мартагддаг энэхүү төсөл олон жилийн дараа хэрэгжихээр болж 2025.01.17-ний өдөр гэрээг албан ёсоор үзэглэв. Энэхүү түүхэн үйл явдал нь Францын “Орона” группт ялалт болж, Монголд гуравдагч хөршийн хоёр дахь том хөрөнгө оруулалтаар дамжин хоёр улсаас “хараат бус” байх боломж бүрдэж буйг эрдэмтэд төдийгүй гаднын томоохон хэвлэлүүд онцолжээ.

УРАНЫ ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Зорилго: Ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд 68.9 мянган тонн уран үйлдвэрлэж, хүлэмжийн хийн ялгарлыг 3.9 тэрбум тонноор бууруулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ.

Санхүүжилт: БНФУ-ын Засгийн газрын шууд хөрөнгө оруулалт

Нийт төсөв	>	2025 онд		2026 онд		2027 онд
1.6 тэрбум\$		95.8 сая\$		108.2 сая\$		140.2 сая\$

Үр дүн: Жилд 2500тн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хугацаанд улс, орон нутагт 5.2 тэрбум\$ татвар төвлөрүүлнэ.





ЗЭЭЛДЭГЧИЙН “ХАР ЖАГСААЛТ” ГЭХ САНХҮҮГИЙН ЯЛ ХАЛАГДЛАА

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Э.Батшугар санаачилж улмаар УИХ-ын чуулганы 2025.05.16-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 13 банк, 400 гаруй банк бус санхүүгийн байгууллага болон төр, хувийн хэвшлийн байгууллагууд Зээлийн мэдээллийн санд иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн мэдээллийг тогтмол нийлүүлдэг. Тус мэдээллийн санд 1.6 сая иргэн, 17 мянган аж ахуйн нэгжийн 4.7 сая орчим зээлийн мэдээлэл хадгалагдаж байна. Хуулийн төсөл батлагдсанаар



“хар жагсаалт” гэх санхүүгийн ялд өртөөд байсан 200 мянган иргэдийн зээлийн муу түүх хүчингүй болж, онооны системд шилжих юм. Гагцхүү Хөгжлийн банк, Засгийн газрын тусгай сангаас зээл авчхаад төлөхгүй бол уян хатан тогтолцоо үйлчлэхгүй. Учир нь энэ бол татвар төлөгчдийн мөнгө тул илүү хариуцлагатай, сахилга баттай байх учиртай.



Э.БАТШУГАР
УИХ-ын гишүүн

Манай улсад зээлдэгчийн зээлжих чадварт үнэлгээ хийх онооны аргалчлалыг эрх бүхий байгууллагаар батлуулах зохицуулалт байхгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Харин зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох асуудлыг эрх бүхий байгууллагаас баталдаг болсноор үнэлгээнд суурилсан банк, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ГАРАХ ЗЭРЭГ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Зээлдэгчийн “хар жагсаалт” гэх санхүүгийн ялыг арилгана;
- Зээлийн хүү, зээлдэгчид тавигдах барьцаа хөрөнгийн шаардлага буурна;
- Санхүүгийн үйлчилгээний хамгийн таатай нөхцөлийг зөвхөн том аж ахуйн нэгж, барьцаа хөрөнгөтэй зээлдэгч хүртдэг тогтолцоог өөрчилж, зээлдэгчийн онооны мэдээлэлд тулгуурлаж зөвхөн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр уян хатан нөхцөлтэй зээлийг санхүүгийн сахилга баттай иргэдэд олгох нөхцөл бүрдэнэ;
- Онооны систем нэвтэрснээр зээлийн эрсдэлийг үнэлэх боломж нэмэгдэж, зээлийн хүртээмж илүү оновчтой болно;
- Банк, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмж сайжирч, салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж иргэд банкны шаардлагаар бус өөрийн хүссэн банкийг сонгон үйлчлүүлдэг болно;
- Банк, санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөөлөлтэй;

Хууль эрх зүйн “Гурван төгөлдөршил” бодлого хэрэгжүүлэхээр ажлын хэсгүүд ажиллаж байна

2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан 126 гишүүнтэй шинэ парламентын өмнө хууль эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх өндөр хариуцлага бий. Тийм учраас шинэ парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа баримтлах үндсэн ГУРВАН чиглэлээ тодорхойлсон юм.

1 Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

2 Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэлд анхаарна.

3 Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргаж ажиллана.

Энэ хүрээнд УИХ-ын даргын захирамжаар 80 орчим ажлын хэсэг байгуулагдан, ажиллаж байна.



Б.БАЯРБААТАР
УИХ-ын гишүүн

Улсын Их Хурлын даргын 2024 оны 59 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, гурилаа дотооддоо 100 хувь хангах хүрээнд цаашдаа ямар бодлого барьж, төрийн дэмжлэгийг хаана үзүүлж, хууль эрх зүйн орчныг хэрхэн сайжруулах вэ гэдэгт анхаарч ажиллаж байна.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Хууль хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй үзэл санаа бүхий байх, нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргадаг болох, хуулийг иж бүрэн зохицуулалттай, тодорхой, ойлгомжтой болгож, хууль болон журмаар зохицуулах харилцааны заагийг тодорхойлоход “ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ”-ийн зорилго оршиж буй. Энэ парламент хууль хүний эрхийн зөрчилгүй байхад анхаарч ажиллахаар зорьж байгаа.



ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БУЮУ УТААНЫ СОНСГОЛ

Нийтийн өргөдөл, гомдлын систем petition.parliament.mn-д Батбаатарын Мөнгөнхишиг иргэний үүсгэсэн “Утааны сонсгол хийцгээе! Төсвийн зарцуулалтад хяналт, үнэлгээ хийж сайжруулцгаая” сэдэвт өргөдөлд 71 мянган иргэн гарын үсэг зурж нэгдсэнээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.1-т заасны дагуу Байнгын хүрээний эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах шаардлагыг биелүүлсэн юм.

- **2024.11.27** Утааны сонсгол хийцгээе! өргөдлийг petition.parliament.mn-д нээв
- **2025.01.15** “Агаарын бохирдол-Хүн амын эрүүл мэнд”-ийн асуудлыг хэлэлцэв
- **2025.01.22** “Зуух, түлшний хяналт, стандартын асуудал”-ыг хэлэлцэв.
- **2025.01.29** “Эрх зүйн орчин, санхүү, хариуцлага”-ыг шүүн нягтлав.
- **2025.02.03** Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр ЕРӨНХИИ ХЯНАЛТЫН СОНСГОЛ зохион байгуулав.
- **2025.04.15** Утааг багасгах шийдэл бүхий 13 заалттай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д танилцуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо шийдвэрлэв.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Монгол Улсад бүтээн байгуулалт хийгдэж байж өнөөдрийн агаар, хөрсний бохирдлоос салж, Монгол хүний амьдрах орчин сайжирна.



Ж.ЧИНБҮРЭН
УИХ-ын гишүүн

Нийслэлээс 32 мянган зуух авах тендер зарлаж, гэр хорооллын айлуудад тараахыг зогсоосон нь уг сонсголын том үр дүн, нөлөөллийн ажил боллоо. Мөн хариуцлагыг нэмэгдүүлэх 13 ажлын чиг үүргийг ЗГ-т хүргүүлээ.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН “ХОРИГ”-ИЙН ХҮРЭЭНД ТӨСВӨӨ ДАХИН ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛЛАА

Улсын Их Хурлын намрын чуулган ирэх оныхоо улсын төсвийг хэлэлцэн баталдаг нь хуулиар тогтоосон үүрэг юм. Гэхдээ 126 гишүүнтэй парламентын намрын чуулган өмнөх намрын чуулгануудын хэвшмэл жишгийг өөрчилж чадсан. Сүүлийн 10 жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын өсөлтийн хувь ойролцоо байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зарлагын хувь нь орлогоосоо дунджаар 4 пунктээр илүү байсаар ирсэн. Улмаар алдагдлыг өр, зээлээр нөхөх замаар шийдвэрлэж, тухайн жилд авсан зээлийн заримыг өмнөх зээлээ төлөхөд, үлдсэн хэсгийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсаар байсан.

МАНАЙ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР

2024 онд
35,2
их наяд төгрөг

2025 оны төсвийн
төсөлд энэ өр даруй
5,0
их наядаар нэмэгдсэн

2010 оноос хойш жил бүр
дунджаар
2,5
их наяд төгрөгөөр нэмэгдсэн

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны улсын төсөвт бүхэлд нь тавьсан хориг нь төсвийг эргэн харах нөхцөл бүрдүүлсний зэрэгцээ төсөв хэлэлцэх дэгийг цаашид сайжруулах шаардлагатай байгааг мөн харууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийг хэлэлцэх дэгийн тухай нэг удаагийн хуулийг хэлэлцэн баталж, улсын төсвийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах хугацааг тусгай дэгээр зохицуулсан юм.

2025 ОНЫ ТӨСВИЙГ ДАХИН ХЭЛЭЛЦСЭНЭЭР

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн

33.5

их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний

35.2

хувьд хүрсэн

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний

3.3

хувийн ашигтай байх төсвийг баталсан.





ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГЫН ОРОН ТООГ ХАСАЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ЯАМДАД ШИЛЖҮҮЛЭВ

Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслүүдийг УИХ-ын чуулганы 2025.06.25-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар ЭЦЭСЛЭН БАТАЛЛАА.

хуулийн төсөлд

- Боомтын сэргэлтийн Үндэсний хороо,
- Хяналт, үнэлгээний Үндэсний хороо,
- “20 минутын хот” Үндэсний хорооны даргын орон тоог хасаж, үйл ажиллагааг нь зарим яамдад шилжүүлэхээр болсон юм.

Тодруулбал

Боомтын сэргэлтийн Үндэсний хороог Сангийн сайдад, Хяналт, Үнэлгээний Үндэсний хороог Тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайдад, “20 минутын хот” Үндэсний хороог Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдад тус тус шилжүүлэхээр тусгаад байна.



П.САЙНЗОРИГ

УИХ-ын гишүүн

Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг дэмжиж байна. Хуульд байхгүй Үндэсний хороо, Зөвлөл нэртэй байгууллагуудыг татан буулгах цаг нь болсон. “ТООН МЭДЭЭЛЭЛ ГАРГАЖ ӨГ” гээд ярвайсан, дарга царайлсан хүмүүс нь яамдын ажлыг хийлгэхгүй байна!



21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ УРАГШИЛЛАА

Улсын Их Хурал мега төслүүд хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байгаа. Тухайлбал “Гашуунсухайт-Ганцмод” хил холболтын төмөр замын төсөл гацаанаас гарсан. Үр дүнд нь экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал хэмжээг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх юм.

2024.12.27

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан юм.

2025.02.14

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т хэлэлцээрт гарын үсэг зурж баталгаажууллаа.

2025.03.27

Гашуунсухайт-Ганцмод боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталлаа.

ЗАМЫН-ҮҮД, ЭРЭЭНИЙ
БООМТ ТӨМӨР ЗАМААР
ХОЛБОГДСОНООС ХОЙШ

70 орчим жилийн
ДАРАА ӨМНӨД ХӨРШТЭЙГӨӨ
ТӨМӨР ЗАМААР ХОЛБОГДОХ

ХОЁР ДАХЬ
БООМТЫН ҮҮД, ХААЛГА
НЭЭГДЛЭЭ.



П.САЙНЗОРИГ

УИХ-ын гишүүн

МУ-ын хил дээр хөнгөн тээврийн хэрэгсэл буюу EGV нэвтрүүлж, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх шийдвэрийг ХЗДХЯ-наас гаргаж байлаа. Тухайн үедээ их шүүмжлэл, ил далд дайралтууд ирж л байсан. Бид баг хамт олноороо зориглон шийдвэр гаргасан. Буруутаагүй гэдгийг одоо харж мэдэрч байна.



ИМПОРТЫН ГУРИЛЫН ТАТВАРЫГ ТЭГЛЭСНИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

2023 оны өвөл 2024 оны хаврын зуднаар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүндрэлийг даван туулах зорилгоор улаанбуудайн дээд болон 1-р зэргийн гурил, есөн нэр төрлийн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөөд байсан юм.

Ингэснээр хилээр орж ирэх гурилын хэмжээ эрс нэмэгдэж, дотоодын гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтворгүй болгон, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үнэгүүдүүлж, үүнээс улбаатай олон сөрөг нөлөөг дагуулж болзошгүй байсан тул импортын гурилын татварыг тэглэснийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэнээр уг хуулийн төслийг УИХ-д хоёр удаа оруулж ирсний эцэст 2025 оны зургаадугаар сарын 25-ны өдөр батлагдав.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Гаалийн үнийг нэг жил чөлөөлж үзлээ. Бид гэнэтийн шийдвэр гаргаж ААН-дэд цохилт өгч болохгүй. Гурилын үйлдвэрүүд хуйвалдаж, монопол байдал бий болгоод байгаа бол Өрсөлдөөний тухай хууль тогтоомжоо сайжруулж, зах зээлийнх нь зарчмаар явуулах хэрэгтэй!



Т.АУБАКИР
УИХ-ын гишүүн

Дотоодын хүнсний үйлдвэрийг тууштай дэмжиж байх ёстой. Үүний цаана үндэсний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал дагаж байдаг. Дотооддоо хүнсээ хангах нь үйлдвэрлэлээ дэмжих нь ямар чухал болохыг Ковид сануулсан шүү.

Монгол Улсын Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх гурил, улаанбуудай
тэргүүтэй 19 нэр төрлийн
хүнсний дотооддоо үйлдвэрлэх
шаардлагатай хэмээн үзэж
“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг
санаачилсан билээ

**Уул уурхайгаас эдийн засгийг
босгох гол тулгуур нь хүнс
хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн салбар байх
ёстой**





“Шинэ Зуун мод” гэх нэршил нь Төв аймгийн төв Зуун мод хотын дагуул хот эсхүл Зуун мод хотыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт гэсэн зөрүү ойлголтыг төрүүлнэ!

ХҮННУ ХОТ ДАРААХ БҮСҮҮДТЭЙ БАЙНА

- Эдийн засгийн чөлөөт бүс
- Шинэ Зуунмод хотын төв, засаг захиргааны бүс
- Оюутны хотхон, судалгаа шинжилгээний бүс
- Тээвэр логистикийн бүс
- Худалдаа, бөөний бүс
- Үйлдвэрийн бүс
- ОУ-ын нисэх онгоцны буудал, агаарын каргоны бүс

ШИНЭ ЗУУНМОД ХОТЫГ “ХҮННУ” ХОТ ГЭЖ НЭРЛЭВ

“Шинэ Зуунмод” дагуул хотыг байгуулснаар Улаанбаатар хотын төвлөрөл тодорхой хувиар буурахаас гадна Богдхаан, Төмөр зам чөлөөт бүс тээвэр логистикийн МУ-ын эдийн засгийн өсөлтийг 10-15% тэлэх боломжтой. Мөн энэ хотод төр захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолбор байрлах бөгөөд олон улсын нисэх буудлыг түшиглэн олон улсын дээд түвшний уулзалт, арга хэмжээ зохион байгуулах цогцолбор байгуулж үйлчилгээний менежмент, аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгоно хэмээн үзэж байна.





МОНГОЛ УЛСЫН ШИНЭ НИЙСЛЭЛ ХОТЫГ ИРЭЭДҮЙД СЭРГЭЭН БАЙГУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДЛЭЭ

УИХ-ын 2024 оны намрын чуулганаар хэд хэдэн бие даасан хууль батлагдсаны нэг нь “Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль”. Хууль батлагдсанаар нүүдэлчдийн түүхэн гал голомт болсон Орхоны хөндийд суурьшсан эртний нийслэлүүдийн туурин дээр Монгол Улсын шинэ нийслэл хотыг ирээдүйд сэргээн байгуулах хууль эрх зүйн орчин бий болсон юм.

2023

УИХ-ын 07 дугаар тогтоолоор Орхоны хөндийд шинэ Хархорум хотыг байгуулахаар шийдвэрлэсэн.

2024

УИХ-ын даргын 12 тоот захирамжаар уг тогтоолын хэрэгжилтийг хангуулах, бүтээн байгуулалтыг дэмжих чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан

2024

Хуулийн төслийг 2024.12.20 нд өргөн мэдүүллээ

2025

Хуулийн төслийг 2025.01.23-нд баталлаа



Г.ТЭМҮҮЛЭН

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Хотын эдийн засгийн үндэс суурь, үзэл баримтлалын хувьд түүхэн өв соёл, үнэт зүйлээ сэргээх, хадгалах асуудалд тулгуурлан олон төрөлт аялал жуулчлалыг дэмжинэ. Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангаж, бие даан хөгжих ёстой!



Н.УЧРАЛ

УИХ-ын гишүүн

Хотыг инженерүүд өөрсдөө л төлөвлөж байгуулж, хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр босгодог. Улаанбаатар хотыг хувийн хэвшил босгосон. Хархорин хот дээр энэ алдааг давтахгүйн тулд төр бас оролцох зүйлдээ оролцоно. Ялангуяа газар олголт дээр оролцох учиртай. Шууд эзэмшүүлж ашиглуулахгүй байх ёстой.





ЦУСАА ХАНДИВЛАХ ҮЙЛ ЯВЦ ЭРСДЭЛГҮЙ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОВСРОНГУЙ БОЛОВ

Монгол улс Донорын тухай хуулиар цусны болон эд эс эрхтний донорын асуудлыг зохицуулж байв. Олон нийтэд цусаа өгөхийг уриалах боломжтой ч эд, эс эрхтний донор болохыг ухуулах нь хүнд сэдэв тул хоёр тусдаа хуулиар зохицуулах шаардлага үүссэн юм. Мөн хүн ам өсөн нэмэгдэхтэй зэрэгцэн цусны хэрэглээ нэмэгдэж, ялангуяа хөдөө орон нутагт цусны нөөц асар дутагдалтай байгаа нь, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Цусны төв”-ийг сайжруулж, халдварт өвчин тархаахгүйгээр ажиллах нөхцөл бүрдсэн нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах үндэс болсон юм.

ЦУСНЫ ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР

- Цусны донорын сургалт, сурталчилгаа сайжирч, орон нутагт ахиц дэвшил гарна
- Цусны донорын нийгмийн халамж, урамшуулал сайжирч, тоо нь нэмэгдэх боломжтой
- Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэнэ

Монгол Улсад 170 мянган цусны донор бий. Тэд 1 удаа цус өгөхөд

500,000

хүний эрүүл мэнд, амь насыг аварч, амьдрал бэлэглэдэг



Ж.ЧИНБҮРЭН

УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд

Эрчүүдэд элбэг тохиолддог, ноцтой эрүүл мэндийн асуудал үүсгэх эрсдэлтэй төмрийн илүүдэл өвчнийг цусны донор болсноор бүрэн шийдвэрлэх боломжтой.



А.АРИУНЗАЯА

УИХ-ын гишүүн

Би өөрөө боломжоороо цусаа өгөхийг хичээдэг. Таны бэлэглэсэн цус 3 хүний амийг аварна гэж хэлдэг бол цагаа тулбал 3 байтугай 30 хүний цус ч багадах тохиолдол байдаг. Цусны нөөц, донорын тоог нэмэгдүүлэхийн тулд сургалт, сурталчилгаа, урамшууллыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хийх нь маш чухал.





ЭД, ЭРХТНЭЭ ШИЛЖҮҮЛЭХ ЭМЭЭГ БӨГӨӨД МАРГААНТАЙ АСУУДЛУУДАД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХИЙГ ЗОРИЛОО

Эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд маш хурдацтай хөгжиж байна. Анагаах ухааны гайхамшигтай үр дүнгүүд иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох, амьдруулах зэргээр хүсэл мөрөөдлийг нь биелүүлдэг болжээ. Ийм учраас цаг үеийн шаардлагаар Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн нарын гишүүд 2025 оны намрын чуулганаар өргөн мэдүүлж хуралдаанаар хэлэлцсэн юм.

Манай улс анх 2006 онд бөөр шилжүүлэн суулгаснаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ эхэлсэн.

- 2011 онд элэг
- 2014 онд ясны чөмөг, үүдэл эс
- 2018 онд элэг шилжүүлэн суулгах баг тус тус байгуулагдаж шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна.



ЭРХТЭН, ЭД ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР

- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж, эмчилгээний аргууд улам нэмэгдэж, хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
- Нийгмийн даатгал төлдөг, эс төлдөг эсэхийг үл хамааран тайтгарлын зардал өгөхөөр тусгасан. Амьгүй донорын гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлэн олгох тэтгэмж бол оршуулгын зардлын хэмжээг тооцсон мөнгөн дүн юм.
- Мөн иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх, гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасаж, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
- Түүнээс гадна эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинө.



ТӨР ӨӨРӨӨСӨӨ ЭХЭЛЖ БҮСЭЭ ЧАНГАЛНА


УИХ-ын чуулганы энэ хаврын чуулганаар 2025 оны төсвийн тодотголыг яаралтай горимоор хэлэлцэж баталлаа. Нүүрсний үнийн огцом уналтаас голлон шалтгаалж төсвийн орлого 3.2 их наяд төгрөгөөр тасалдах бодит нөхцөл байдал үүссэн. Энэ нөхцөл байдал цаашид даамжирч болзошгүй байгаа. Иймд Засгийн газар “төр өөрөө бүсээ чангалах” хувилбарыг сонгож байгаа. Энэ нь төрийн бүтээмж, үр ашгийг сайжруулах томоохон шинэчлэлийн эхлэл болно гэдгийг Ерөнхий сайд Г.Занданшатар онцлон тэмдэглэж байв.

- Төсөвт байгууллагуудын түлш, халаалтын тарифыг нэмэгдүүлэхээр туссан зардлыг 121.9 тэрбум төгрөгөөр,
- Төрийн тусгай байгууллагуудаас бусад төсвийн байгууллагуудын тээвэр, шатахуун, дотоод албан томилолт, хурал зөвлөгөөний зардлыг 28.9 тэрбум төгрөгөөр,
- Төрийн өндөр дээд айлчлал, зочид төлөөлөгч хүлээж авахаас бусад гадаад томилолт, зочид хүлээж авах зардлыг 4.5 тэрбум төгрөгөөр,
- Бүх шатны төсвийн байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх болон багаж, техникийн зардлыг 104.4 тэрбум төгрөгөөр,
- Төсвөөс төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаасыг 76.8 тэрбум төгрөгөөр,
- Байгууллагаас олгох нэг удаагийн болон бусад тэтгэмж, урамшууллыг 30.2 тэрбум төгрөгөөр,
- Бүх шатны төсвийн байгууллагуудын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлыг 617.3 тэрбум төгрөгөөр хэмнэнэ.

Ингэснээр төсвийн зардал **1 их наяд 508.4 тэрбум** төгрөгөөр буурна гэж үзжээ. Төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар цөөлж **261 тэрбум** төгрөгөөр хэмнэхээр тооцсон байна.

Төсвийн энэхүү тодотгол нь төсөв, мөнгөний бодлогын уялдааг сайжруулж, төлбөрийн тэнцэлд учирч болзошгүй сөрөг дарамтыг 400 орчим сая ам.доллаар бууруулж, монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтворжуулах, үнийн өсөлтийг сааруулах, эдийн засгийн тогтвортой байдал, ард иргэдийн амьжиргаа, баялаг бүтээгчдийн хэвийн үйл ажиллагаанд зохих үр нөлөө үзүүлнэ гэж үзжээ.





НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН ӨДРҮҮД АМРАЛТЫН ӨДӨРТЭЙ ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ДАРААГИЙН ӨДӨРТ ШИЛЖҮҮЛНЭ

Монголчуудын уламжлалт Сар шинийн баяр, Үндэсний их баяр наадмаар түмэн олон өргөн дэлгэр, хоногт баригдахгүй, тайван баярлахыг хүсдэг ч Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд “Сар шинийн баяраар билгийн тооллын шинийн 1,2,3-ны өдөр бүх нийтээр амарна”, “Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярыг долоодугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15;” гэж тус тус зааж, хуульчилсан. Гэтэл зарим жилд шинийн нэгэн тасрах, мөн амралтын өдөр золголт, баяр наадмын өдрүүд тохиох зэрэг ойлгомжгүй асуудал үүсэж, иргэд талцаж, мэтгэлцсээр удаж байна.

УИХ-ын гишүүн О.Батнайрамдал, Б.Уянга нарын нэр бүхий гишүүд нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд шаардлагатай зохицуулалтыг тусгаж, нийтээр тэмдэглэх баярын өдөр амралтын өдөр тохивол дараагийн өдөрт шилжүүлэхээр тусгалаа.

ХУУЛЬ ТУСГАГДСАН НИЙТЭЭР АМРАХ БАЯРЫН ӨДРҮҮД

Шинэ жил **01.01**

Цагаан сар-шинийн **1, 2, 3**

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр **03.08**

Хүүхдийн баяр **06.01**

Бурхан багшийн их дүйчин өдөр
Зуны тэргүүн сарын шинийн **15**

Үндэсний их баяр наадам
07.10-07.15

Их Эзэн Чингис хааны
мэндэлсэн өдөр
Өвлийн тэргүүн сарын шинийн нэгэн

Бүгд найрамдах улс тунхагласны баяр
11.26

Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо
сэргээсний өдөр **12.29**



УРАНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭНЭЭР ХУРИМТЛАЛЫН САН АРВИЖНА



Тогтоолын төсөл батлагдсанаар

- Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт байрлах “Дулаан-Уул”, “Зөвч-Овоо”, “Өмнөт” гэсэн талбайд цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадрах Энержи” ХХК-ийн төрийн эзэмшлийн **34** хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр /АМНАТ/ болон **10** хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулах асуудлыг тусгав;
- Засгийн газар **10%** -ийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцааг эзэмшсэнээр бусад энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжид ноогдол ашиг хүртэнэ;
- Хувьцаанд ноогдох хөрөнгө оруулалт хийх үүрэг хүлээхгүй байх бүтээгдэхүүний **10** хүртэлх хувийг хөрөнгө оруулагчтай ижил нөхцөл болзлын дагуу худалдан авах боломж бүрдлээ.

Дэлхий нийтээрээ цөмийн эрчим хүчийг ногоон буюу тогтвортой цэвэр эх үүсвэр хэмээн зарлаж байна. Дэлхийн зах зээлд цөмийн түлш ураны хэрэгцээ жил бүр тасралтгүй өсөж байгаа.

Манай улсад 192,2 мянган тонн ураны нөөц бүртгэсэн нь дэлхийн ураны нөөцийн 3%-ийг бүрдүүлж, нөөцийн хэмжээгээр дэлхийд 10-д жагсаж байгаа юм. Тэгвэл Монгол Улс үүнд анхаарлаа хандуулан урт хугацааны хөгжлийн бодлогодоо энэ талаар тусгаж, тодорхой ажил хийсээр байна. Тухайлбал, энэ хүрээнд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газраас өргөн барьж, УИХ-ын чуулганы /2025.01.09/-ний өдрийн хуралдаанаар баталлаа.



П.САЙНЗОРИГ
УИХ-ын гишүүн

Манай улс дан ганц нүүрсний экспортоос хараат байж болохгүй. Нүүрсний үнэ унахад эдийн засагт асар том цохилт өгнө. Тиймээс бусад төрлийн буюу Уран болон газрын ховор элементүүдийг олборлох ёстой.



МОНГОЛ УЛСЫН
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ТҮҮХЭН ДЭХ
ЕС ДЭХ УЛСЫН ИХ ХУРАЛ

